

МЭӨ 185 ОНД БИЧСЭН ХҮННҮГИЙН ХААНЫ ЗАХИДАЛ

А. ДАМДИНСҮРЭН

Түүхийн ухааны дэд эрдэмтэн

Төв Азид Хүннү нэртэй нүүдэлчин аймаг оршин тогтнож байсан тухай мэдээ эртний хятад сурвалж бичигт олон мянган жилийн тэртээгээс эхлэн нэр гарч тэмдэглэгдэн иржээ.

«Ши цзи» хэмээх түүхийн тэмдэглэлийн дотор байгаа «Таван хааны сурвалж тэмдэглэлд» Хуанди гэдэг хүн Сюньюй-Хүннү нарыг умар зүг хөөсөн гэж өгүүлсэн байдаг. Хуанди бол Хятадын балар эртний хүй нэгдлийн нийгмийн үед амьдарч байсан домогт хүн ажээ. Он цаг нь барагцаалбал МЭӨ 6000 жилийн орчим юм гэж тэнд дурджээ.

Үүнээс үзэхэд Хятадад овгийн байгуулал бүрэлдэж байсан үед, хүннү гэдэг овог аймаг болчихоод Хятадтай айл хөрш зэрэгцэн оршиж байсныг энэ баримт нотлож байгаа юм.

Хүннү нар нь ийнхүү оршин тогтнож байх үедээ түүхийн маш урт удаан хугацааны турш янз бүрийн хүнд бэрх сорилт шалгалтуудыг даван туулж ирсний үр дүнд амьдрал тэмцэл, хөдөлмөр, оюун санааны талаар асар их баялаг туршлага хуримтлуулж, түүнийгээ хойт үедээ өвлөн үлдээж өгсөн өнө эртний нүүдэлчид юм.

Одоогийн БНМАУ-ын нутаг дэвсгэрээр гол төв болгосон Монгол нутаг дээр МЭӨ III зуунд Хүннү нар анх төр улс байгуулсан түүхтэй билээ. Хүннү нар ийнхүү төр улс байгуулан өргөн уудам нутаг дэвсгэртэй ихээхэн хүчирхэг гүрэн болж байсан тухай гадаад дотоодын янз бүрийн сурвалж бичигт олонтой тэмдэглэгдсэн байдаг.

Тэр үед Төв Азид Хятадын Хан улс, Хүннү хоёр гол том улс өрсөлдөж байжээ. Японы түүхч Сибаретаро; «... Азийн түүх бол морь унасан малчин, тариачин улсын хоорондын тэмцлийн түүх байсан»¹ юм гэж бичжээ.

Тухайн үед үнэхээр Ази тивд Хүннү, Хятад хоёр том гүрэн хүч тэнцүү, эрх тэгш, бодитойгоор зэрэгцэн оршиж байх цагт хоёр гүрний хооронд, янз бүрийн харилцаатай байжээ.

Ийнхүү Хүннү нар Хятадтай хүч чадлаар тэнцүү байх үед Хүннүгийн Модун Шаньюй хаанаас Хятадын Хан улсын хаанд МЭӨ 176 онд (Вэнь ди хааны өмнөх 6-р он. МЭӨ 185 онд) илгээсэн нэг захидал Хятадын «түүхийн тэмдэглэл Ши цзи» хэмээх түүхийн эртний сурвалж бичгийн 2896-р талд байгаа Хүннүгийн шастир гэдэг хэсэгт хятад хэлээр тэмдэглэгдэн үлдсэнийг монгол хэлнээ орчуулж, галиг, хятад эхийг хойно хавсаргав.

Уг захидлын Монгол орчуулга

«Одоо өчүүхэн би хуучин гэрээг цуцалж, баруун гарын Мэргэн ванг яллаж, түүнийг баруун зүг Юечжиг цохиулахаар илгээв. Тэнгэрийн буянгаар, миний цэрэг хүчтэй, морь хурдан тул Юечжиг эцэст хүртэл цохин сөнөөж, буулган авав. Лоулан, усунь, хуцзе болон бусад 26 улс

¹ Сибаретаро «Гайто-о юку» Токио, 1974 389 (Сибаретаро «Замаар одохуйд» Токио. 1974)

бүгдээрээ Хүннүгийнх болов. Нум сумтай бүх хүнийг нэг гэр нэгтгэв гэжээ.

Захидлын хятад үсгийн галиг

Цзинь и сяо ли чжи бай юе гу, фа ю сянь ван, ши чжи си цю юе чжи чжи чжи. И тянь чжи фу, Ли цзу лян, ма цян ли, и и ме юе чжи, цзинь чжань ша цзян ся чжи.

Дин Лоулан, у сунь, ху цзе цзе ци пан эр ши лю го, цзе и вэй сун ну. Чжу инь гун чжи минь, бин вэй и цзя.

Захидлын хятад эх

Энэхүү захидлын үг хэллэгийн байдал, эртний хятад хэлний найрлага, тэр үед тогтмол хэрэглэж байсан үг, үсэг зэргийг ажиглаж үзвэл, Хүннүгийн хаан эл захидлаа анх шууд хятад хэлээр бичээгүй, харин хүннү хэлээр, хүннү бичгээр бичиж ирүүлснийг Хан улсын хааны ордоны бичгийн түшмэдүүд хятад хэлэнд орчуулсан захидал байна гэж судлагчийн хувьд үзэж байна.